



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/149

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 03/07 дугаар тогтоолын 3.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хужирт, Хархорин сумдад "Ковид-19" цар тахлын голомтын тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор тусгаарлах байр бэлтгэх, түүнд ойрын хавьтлуудыг тусгаарлах, иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлахад эргүүл, хяналтын цэг ажиллуулахад гарсан 115,345,000 (нэг зуун арван таван сая, гурван зуун дөчин таван мянга) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх 115,345,000 (нэг зуун арван таван сая, гурван зуун дөчин таван мянга) төгрөгийн зардлаас 85,345,000 (наян таван сая гурван зуун дөчин таван мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас, үлдэгдэл 30,000,000 (гучин сая) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас тус тус зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100322

Аймгийн Засаг даргын 2021 оны...
 дугаар сарын ...-ны өдрийн ... дүгээр
 захирамжийн хавсралт



**ХУЖИРТ, ХАРХОРИН СУМДАД КОВИД-19" ЦАР ТАХЛЫН
 ҮЕД ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ТООЦОО**

д/д	Зардлын зүйл анги	Зардлын мөнгөн дүн /төгрөгөөр/
1. Хужирт сум		
1	Тусгаарлан ажиглах байр бэлтгэх зардал /тусгаарлан ажиглах байр-1-Газарчин, тусгаарлан ажиглах байр-2-Хужирт рашаан сувилал, тусгаарлан ажиглах байр-3-Ананд рашаан сувилал/	3,000,000.00
2	Тусгаарлах эмнэлгийн ор хоногийн урьдчилгаа зардал /Сэмжид рашаан сувилал/	10,000,000.00
3	Тусгаарлан ажиглах байр 1-д тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал /Газарчин/	31,700,000.00
4	Тусгаарлан ажиглах байр 2-д тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал /Хужирт Рашаан сувилал/	31,900,000.00
5	Тусгаарлан ажиглах байр 3-д тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал/Ананд/	8,250,000.00
6	Аймаг, нийслэлээс томилогдон ажилласан албан хаагчдын байр, хоолны зардал	2,495,000.00
7	Хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүлийн тээврийн шатахууны зардал	5,000,000.00
Хужирт сумын дүн		92,345,000.00
2. Хархорин сум		
8	Хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүлийн тээврийн шатахууны зардал	2,000,000.00
9	Тусгаарлан ажиллах байр бэлтгэх зардал	2,000,000.00
10	Тусгаарлан ажиглах байр "Тумбаш зочид буудал"-д тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал	3,400,000.00
11	Тусгаарлан ажиглах байр "Тумбаш зочид буудал"-д ажилласан эмчилгээ, хариу арга хэмжээний багийн ор хонгийн зардал	3,900,000.00
12	Тусгаарлан ажиглах байр "Заяа зочид буудал"-д тусгаарлагдсан багийн гишүүдийн ор хоногийн зардал	2,100,000.00
13	Тусгаарлан ажиглах байр "Заяа зочид буудал"-д тусгаарласан хүмүүсийн ор хоногийн зардал	5,700,000.00
14	Тусгаарлан ажиглах байр "Заяа зочид буудал"-д ажилласан эмчилгээ, хариу арга хэмжээний багийн ор хоногийн зардал	3,900,000.00
Хархорин сумын дүн		23,000,000.00
Нийт зардлын дүн		115,345,000.00